

ОЛОН УЛСЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ТӨЛӨВШИЛД МЭДЭЭЛЛИЙН САЙТЫН  
ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ҮҮРЭГ, МЭДЭЭЛЛИЙН ҮНЭЛЭМЖИЙН ЗАРИМ  
АСУУДАЛД

Э.Энхчимэг\*

\*МУИС-ийн сэтгүүл зүйн магистр (МА)

**Түлхүүр үг:** олон улсын сэтгүүл зүй, олон улсын мэдээлэл, гадаад мэдээ, мэдээллийн сайт, мэдээллийн үнэлэмж

Олон улсын сэтгүүл зүй хэмээх ойлголт сэтгүүл зүйн нэгэн салбар болж хөгжсөнөөс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд тухайн цаг үеүдийн нийгмийн онцлогоос шалтгаалан аливаа асуудлыг тусгах хэв маяг, хамрах хүрээ өөрчлөгдсөөр ирсэн. Дэлхийн улс хоорондын хамтын ажиллагаа, эдийн засгийн түншлэл, харилцан хамаарал нэмэгдэж байгаа энэ үед олон улсын сэтгүүл зүйн гүйцэтгэх үүрэг урьд урьдынхаас илүү нэмэгдэж, хариуцлагатай болж байна. Өнөөдөр сэтгүүлчид олон улсын харилцааны асуудал болон үзэгдэлд дипломатч, эрх мэдэлтнээс дутахааргүй нөлөө үзүүлж, улс орны гадаад бодлогыг дэмжих, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад ихээхэн үүрэгтэй оролцох болов. Иймд хэвлэл мэдээллийн байгууллагуудын тэр дундаа интернэт сүлжээний тусламжтайгаар орон зай, цаг хугацаанаас үл хамааран нэгэн зэрэг өргөн хүрээнд мэдээлэл түгээж буй мэдээллийн сайтуудын гадаад мэдээний үнэлэмж, мэдээллийн агуулга, хүртээмжийн асуудалд тухай бүрд судалгаа хийж олон улсын сэтгүүл зүйн төлөвшилд хэрхэн үүрэг гүйцэтгэж

буйд үнэлэлт дүгнэлт өгөх нь зүйн хэрэг юм.

Мэдээллийн тасралтгүй урсгал дунд амьдарч буй өнөө үед “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд асар ялгаатай, өргөн хүрээний хүлээн авагчдад хүрч, дамжуулж буй мэдээллээрээ тэднийг ойртуулж, холдуулахад ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлэх болсон. Хиймэл дагуул, интернэтийн тусламжтайгаар түгээж буй мэдээ мэдээлэл дэлхийн өнцөг булан бүрд цацагдаж, улмаар засгийн газар, цэрэг арми, хүмүүнлэгийн байгууллага, дайн самуунтай угсаатны бүлгүүдийн үйл хөдлөлд ч нөлөөлж байгааг үгүйсгэхгүй. Тиймээс янз бүрийн шашин, уламжлал, угсаатны бүлэг бүхий ард иргэдэд нэгэн зэрэг хүрч байдаг олон улсын мэдээлэлд тавигдах шаардлага, үнэлэмжийг зайлшгүй тодорхойлох учиртай. Олон улсын мэдээ мэдээлэл нь улс орнуудын харилцаа холбооны үүднээс шүүн тунгаасан, үнэн зөв, тэнцвэртэй, олон ургалч байх гэсэн шаардлагад нийцэх ёстой”<sup>1</sup> юм.

Олон улсын сэтгүүл зүй нь улс орноо гадаадад таниулах, гадаад мэдээллээр иргэдээ хангах гэсэн хоёр чиглэлээр төлөвшиж байгаа бөгөөд онолын хувьд улс хоорондын мэдээлэл дамжуулах түвшнийг үндсэн “гурван шалгуураар”<sup>2</sup> үнэлнэ гэж үздэг. Нэгдү-

гээрт, тухайн улсын эдийн засаг, улс төр, цэргийн хүчнээс хамаарал бүхий үндэсний эрх ашигт нөлөө үзүүлэхүйц улсуудын мэдээлэл. Хөгжингүй эдийн засагтай болон улс төрийн нөлөө бүхий улс орнуудын мэдээлэл нь олон улсын сэтгүүл зүйн мэдээллийн урсгалд голлох байр суурьтай байна. Хоёрдугаарт, хөрш орнуудын мэдээлэл. Газар зүйн байршил ойр, хүн ам зүйн хувьд соёлын ижил төстэй орнуудын мэдээ мэдээллийг тухай бүрд мэдээлэх. Гуравдугаарт, үйл явдлын мэдээ. Тухайн улсын үндэсний хэмжээнд өрнөж буй эдийн засаг, улс төр, нийгмийн голлох үйл явдал, зөрчилдөөний талаар мэдээлэх гэсэн шалгууруудыг баримтлах нь зүйтэй гэж заасан байдаг. Практикийн хувьд авч үзэхэд, жишээлбэл, олон улсын мэдээллийн урсгалын голлох эх сурвалж болдог АНУ нь нэгдүгээрт, эдийн засаг, хоёрдугаарт, улс төр, гуравдугаарт соёл нийгмийн ач холбогдлыг харгалзан үздэг бол Европын улс орнууд олон улсын мэдээллийг дотооддоо дамжуулахдаа үндэсний, европын, дэлхийн хэмжээний гэсэн шалгуур тавьж байна.

Түүнчлэн олон улсын мэдээллийг түгээхэд, тухайн үйл явдал нь “Чиг хандлага болж буй эсэх, мэдээллийг хүртэх хэрэглэгчдэд урам зориг өгөх, чиглүүлэн таниулах, мэдлэг олгох, алс хэтэд нь үр өгөөжтэй байх”<sup>3</sup> зэргийг харгалзан үзэх шинэ хандлага бий болж байгааг сэтгүүл зүй судлаачид хэлж байна.

Харин манай улсын тухайд онолын хувьд дээрхтэй төстэй үнэлэмжээр буюу “Өмнөд хойд хоёр хөршийн, эдийн засгийн нөлөө дэмжлэг үзүүлэх орны, дэлхий нийтийн тулгамдсан зөрчилт асуудал”-ын хүрээнд олон улсын мэдээ мэдээллийг дамжуулбал зохино хэмээн Профессор, доктор

Б.Болд-Эрдэнэ тодорхойлжээ. Үүнд манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон улсын мэдээг түгээхдээ гуравдагч хөршийн бодлогыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, манай улс гадаад харилцаандаа хоёр хөршийнхөө шууд нөлөөг гуравдагч нэгнээр тэнцвэржүүлэх бодлого баримталдаг учраас Монгол Улсын аюулгүй байдалд эерэг, сөрөг нөлөө бүхий байдал үүсэх нь хоёр хөрш болоод гуравдагч хөрштэй харилцаагаа хэрхэн төлөвшүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлын шүтэлцээнд хэрхэн оролцохоос хамаардаг. Энэ хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ хэмээн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан байна. Үүний дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон тулгуурт гадаад бодлогыг баримталж, гуравдагч хөрш орнуудын мэдээ мэдээлэл дамжуулахдаа төвийг сахиж, шүүлтүүртэй хандах нь зүйтэй.

Олон улсын мэдээллийг дамжуулах үнэлэмж, шалгуурыг дээр дурдсанчлан онолын хувьд тодорхойлсон байдаг ч практик дээр хэрхэн хэрэгждэг болохыг Монгол дахь хамгийн их уншигчтай, өргөн хандалттай Gogo.mn, Ikon.mn, News.mn хэмээх гурван мэдээллийн сайтын энэ оны есдүгээр сарын 1-ний өдрөөс аравдугаар сарын 1-ний өдөр хүртэлх нэг сарын хугацаанд нийтлэгдсэн нийт 477 гадаад мэдээнд тулгуурлан авч үзвэл, олон улсын мэдээлэл дамжуулах үндсэн шалгуурыг хангалтгүй биелүүлсэн буюу учир дутагдалтай, мэдээлэл хүлээн авах хэрэглэгчдэд дэлхийд болж буй үйл явдлаас ямар мэдээллийг хүргэх нь илүү үр ашигтай болохыг

тооцоолоогүй мэдээллүүд зонхилж байна. Тодруулбал,

Сэдэв	Gogo.mn	lkon.mn	News.mn
Улс төр	20	35	54
Эрүүл мэнд	34	30	39
Гэмт хэрэг, дайн, осол	15	27	53
Нийгэм, сонин хачин	27	12	25
Шинжлэх ухаан, технологи	3	16	15
Сошиал медиа	5	10	4
Эдийн засаг	4	2	13
Боловсрол	2	2	1
Урлаг	4	5	5
Спорт	3	4	1
Уул уурхай, эрдэс баялаг	1	1	5

Хүснэгт 1. Олон улсын мэдээнд тусгагдсан нийтлэг сэдэв (тоогоор)

Дээрх хүснэгтээс харвал, Gogo.mn сайтад эрүүл мэнд, нийгэм-сонин хачин, улс төрийн, lkon.mn сайтад улс төр, эрүүл мэнд, гэмт хэрэг, дайн ослын, news.mn сайтад улс төр, гэмт хэрэг, дайн осол, эрүүл мэндийн сэдэвтэй мэдээллүүд зонхилж байна.

**Т**ухайн цаг үеийн үйл явдлын онцлогоос хамааран зонхилох мэдээллийн сэдэв өөр өөр байж болох бөгөөд судалгаа хийх хугацаанд эрүүл мэндийн сэдэвт мэдээлэл тэргүүлж байгаа нь дэлхий даяар цар тахал гарсантай холбоотой байлаа. Уг сэдэв зонхилох байр суурийг эзэлж байгаа нь сайшаалтай ч мэдээллийн агуулгын ач холбогдлын хувьд учир дутагдалтай байна. Тухайлбал, цар тахлын халдвар илэрсэн тохиолдлыг өдөр бүр, улс нэг бүрчлэн мэдээлэх шаардлагагүй бөгөөд нэгтгээд тойм бичиж болох юм. Мөн алдартай жүжигчин, тамирчин коронавирусын халдвар авлаа гэх зэрэг мэдээллүүд нь хүлээн авагчдад төдийлөн ач холбогдол багатай гэж үзэж байна. Цаг үеийн энэ онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор гадаад орнуудын эдийн засгийн болон дэлхийн эрдэс баялгийн мэдээллүүдэд анхаарал хандуулан дамжуулах

болов уу гэж төсөөлж байсан ч харамсалтай нь энэ төрлийн сэдвийн мэдээллүүд маш цөөн байж нийгэм-сонин хачин, сошиал медиа мэдээллүүд түлхүү байв. “Нэг талаар энэ нь олон нийтийн сонирхол, тодорхой хүрээний эрэлт хэрэгцээ мөн боловч нөгөө талаар хэвлэлийн гадаад мэдээллийн ихэнх зайг эзэгнэх агуулга байх нь хүлээн зөвшөөрөхүйц үзэгдэл биш” хэмээн профессор, доктор Б.Болд-Эрдэнийн дүгнэсэнтэй санал нэгдэхэд хүргэлээ. Түүнчлэн гадаад мэдээний ихэнх хувийг эзэлж буй гэмт хэрэг-дайн ослын сэдэвтэй мэдээллүүд нь байшин барилгын нуранги, байгалийн гамшиг, хүн амины хэрэг зэргийг тусгаж байсан нь олон нийтэд хүртээмж багатай, ач холбогдолгүй мэдээллүүд гэж үзэв. Улс төрийн сэдэвт мэдээллүүдийг авч үзвэл, айлчлал, төрийн шийдвэр, уулзалтын мэдээллүүд зонхилж байна. Харин шинжлэх ухаан, технологийн мэдээллийн эзлэх багтаамж дээгүүр байгаа нь сайшаалтай байлаа. Мөн дээрх сэдвүүдийн хүрээнд Монгол улстай холбогдуулан “Байгалийн гамшигийн анхааруулсан мэдээлэл, Монгол улсад зорчих зэрэглэлийн талаарх АНУ-ын Төрийн Департаментын шийд-

вэр, АНУ-д Монгол эмэгтэй хэрэгт холбогдсон тухай болон Цар тахалтай холбоотойгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Монгол улсын талаар онцолсон” гэх зургаан мэдээ нийтлэгджээ. Олон улсын мэдээлэлд тусгагдаж буй сэдвийн хүрээ болон мэдээллийн хүртээмж ийнхүү явцуу байгаа нь

Сайтын нэр	Эерэг	Сөрөг	Дундыг баримталсан
Gogo.mn	49	46	23
Ikon.mn	54	56	34
News.mn	59	114	42

Хүснэгт 2. Олон улсын мэдээний агуулга ба хандлага (тоогоор)

Олон улсын мэдээлэлд сөрөг мэдээ их байгаа нь гэмт хэрэг, дайн ослын талаарх болон эрүүл мэндийн (цар тахлын) сэдэвтэй мэдээллүүд зонхилж байгаатай холбоотой юм. Эерэг агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, нийгмийн амьдралын сонин хачин, социал медиа сэдэвт мэдээллүүд бүрдүүлж байна. Ер нь “манай гадаад мэдээ, нийтлэл нэвтрүүлэг улс орны хөгжил дэвшлийн магтаал болоод байгаль ертөнцийн байдал эсвэл дайн байлдаан хямрал зөрчил, гэмт хэргийн сонин хачин болчхоод байгаа нь олон улсын сэтгүүл зүйн гажуудал гэхээр үзэгдэл”<sup>4</sup> гэж болно.

**Б**ичлэгийн төрөл зүйлийн хувьд, Gogo.mn 111 мэдээ, 7 нийтлэл, Ikon.mn 139 мэдээ, 1 ярилцлага, 3 нийтлэл, 1 тойм, News.mn 191 мэдээ, 24 нийтлэл нийтэлсэн байна. Эдгээр 477 мэдээллээс Ikon.mn АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээний тойм болон “What if” номын талаарх сэтгэгдэл зэргийг сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар гаргаж бичсэн бол бусад мэдээ, нийтлэл нь шууд орчуулгын мэдээлэл байлаа. Олон улсын мэдээлэл дамжуулах явц нь зөвхөн орчуулга хийх төдий ажил биш бөгөөд Монгол улсын нийгэм

хэрэглэгчдийг мэдэхийг хүссэн мэдээллээр биш, мэдэх ёстой мэдээллээр хангах сэтгүүл зүйн зарчим алдагдаж байна гэж үзэхэд хүргэлээ. Түүнчлэн, эдгээр мэдээллийг агуулга, хандлагын хувьд дараах байдлаар ангилж үзүүлбэл,

эдийн засаг, улс төр, олон нийтийн санаа бодолд ямар нөлөөтэй, хамааралтай, цаашлаад үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж болох талаар үнэлэлт, дүгнэлт хийж бичих боломжтой үйл ажиллагаа билээ. Мөн эдгээр мэдээлэлд дурдагдсан улсуудыг авч үзвэл,

Gogo.mn	Ikon.mn	News.mn
ОХУ	ОХУ	ОХУ
БНХАУ	БНХАУ	БНХАУ
Солонгос	Өвөр монгол	АНУ
Япон	Венесуэл	Солонгос
Беларусь	АНУ	Украин
Камбож	Казахстан	Ливан
Франц	Итали	Иран
Энэтхэг	Тайвань	Франц
Тайланд	Канад	Хонгконг
АНУ	Франц	Япон
Герман	Ливан	Энэтхэг
Бразил	Турк	Их Британи
Англи	Шинэ Зеланд	Тайланд
Хонгконг	Мексик	Герман
		Беларусь



нийгэм, гадаад харилцааны сэдэвт манай улсад хамааралтай, мэдэж байвал зохих мэдээллүүдээс илүү дэлхий нийтийн тулгамдсан зөрчилт асуудал буюу дайн самуун, байгалийн гамшиг, дэлхийн оддын амьдрал, дуулиан шуугиан бүхий мэдээллүүд жин татаж байгаа нь олон улсын мэдээлэлд хандах үнэлэмж онолын дагуу хэрэгждэггүй гэж үзэх үндэслэл болж байна.

Олон улсын мэдээлэл түгээж буй арга барилын тухайд Ikon.mn, Gogo.mn мэдээллийн сайтууд “Дэлхийд” нэртэй буланд нийтэлдэг бол News.mn нь “Мэдээ, ярилцлага, нийтлэл, халуун сэдэв, хөрш орнууд, бүс нутаг, CCTV, Риа Новости, бусад” зэргээр төрөлжүүлэн нийтэлдэг нь мэдээлэл хүлээн авахад эмх цэгцтэй, хүртээмжтэй байлаа.

Монгол дахь хамгийн их хандалттай гурван мэдээллийн сайтад нэг сарын хугацаанд нийтлэгдсэн олон улсын мэдээллүүдэд ажиглалт хийсэн нь цаг хугацааны хувьд богино тул мэдээллийн сэдэв, агуулга, үнэлэмжийг тодорхойлоход учир дутагдалтай байж болох ч дүгнэлтээс их хол зөрөхгүй гэдэгт итгэлтэй байна.

**Д**үгнэлт: Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг бодвол дуу, дүрс, текстийг нэгэн зэрэг үзүүлэх боломжтой мэдээллийн сайт нь олон улсын сэтгүүл зүйн төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд мэдээллийн сайтуудын олон улсын мэдээллийг түгээх хандлага, үнэлэмжийн асуудалд тухайлсан хугацаанд ажиглалт хийж дүгнэхэд олон улсын мэдээлэл дамжуулах үндсэн шалгуур болон олон улсын сэтгүүл зүйн үнэлэмжид тавигдах чиг баримжаа урвуу байгаа нь ажиглагдлаа.

Мэдээллийн сайтуудын өдөрт нийтэлж буй гадаад мэдээний багтаамж

(тоо) хангалттай хэдий ч мэдээллийн ач холбогдол, хүртээмжийн хувьд нөлөө багатай болох нь олон улсын мэдээний сэдэв, агуулга, хандлагаас харагдаж байна. Мөн Монгол дахь мэдээллийн сайтууд хэд хэдэн эх сурвалжаар дамжуулан олон улсын мэдээллийг тогтмол дамжуулж байгаа ч үйл явдлыг өөрийн биеэр сурвалжлаагүй, үйл явдал үзэгдэлд улс орны өнцгөөс хандаагүй байдал нь эх сурвалжийн үзэл суртлыг түгээгч болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол дахь олон улсын сэтгүүл зүйн төлөвшилд мэдээллийн сайтуудын гүйцэтгэж буй үүрэгт үнэлэлт өгвөл, олон улсад болсон үйл явдалд “хуурай” буюу идэвхгүй мэдээлэл түгээж, дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж байна гэж үзлээ. Мэдээллийн сайтууд олон улсын мэдээллийг түгээхдээ геополитик, харилцан хамаарлаас илүүтэй “Юу болсон бэ” гэдэг сониучирхсан байдлаар хандаж байгаа нь ажиглагдлаа.

Иймд мэдээллийн сайтууд олон улсын мэдээллийг түгээн нийтлэхдээ тухайн үйл явдлын учир шалтгаан, үр дагавар, үр нөлөө, хэтийн төлөв зэргийг дурдаж, хүлээн авагчдад хүртээмжтэй эсэхийг бодолцон, олон улсын дипломатчийн үүднээс чиглүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

### Эшлэл

- <sup>1</sup> Stephen J.A Ward. Global Media ethics. The University of Wisconsin-Madison. 2013
- <sup>2</sup> Segev, Elad. International News Online: Global Views with Local Perspectives. New York. 2016. p 139-153
- <sup>3</sup> Charlie Beckett. Emotion as an organizing principle for networked journalism. Northwestern University. 2019.04
- <sup>4</sup> Болд-Эрдэнэ Б. Шинэ үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй. УБ. 2005. Х-3

<sup>5</sup>Болд-Эрдэнэ Б. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй. УБ. 2005

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Болд-Эрдэнэ Б. 2005. Шинэ үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй. УБ.
2. Норовсүрэн Л. 2005. Олон улсын мэдээлэл дэх геополитикийн зарим асуудал. УБ.
3. Michael Bromley. Vera Slavtcheva-Petkova. 2018. Global Journalism: An Introduction. London.
4. Peter Berglez. 2013. Global Journalism: Theory and Practice (Global Crises and the Media Book 11) 1st Edition. New York.
5. Charlie Beckett. 2019. Emotion as an organizing principle for networked journalism. Northwestern University. Lecture.

6. Ethical Journalism Network. 2020. Global Press Style Guide.

#### **Summary**

At this time when the international relations, economic cooperation, and multilateralism become more and more crucial, international journalism plays more important role than before. Therefore, the same as the diplomats, the journalists also create a great influence in forming international relations and have an important impact in supporting the foreign policy and national security strategy. Thus, using the media network and the internet, we need to conduct a survey on every news and every article of the news sites and evaluate how they affect the formation of international journalism.